



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 36

Улаанбаатар хот

“Миг даатгал” ХХК-д хувь нийлүүлсэн
хөрөнгийн хэмжээндээ өөрчлөлт оруулахыг
зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 355 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Миг даатгал” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тус компанийн хувь нийлүүлэгч нарт хуваарилсан ногдол ашиг 750,000,000 /долоон зуун тавин сая/ төгрөгөөр нэмэгдүүлж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

№	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	
1	Ж.Бат-Орших	385 000 000,00	105 000 000,00	490 000 000,00	14%
2	Х.Ганбаатар	302 500 000,00	82 500 000,00	385 000 000,00	11%
3	У.Бямбасүрэн	302 500 000,00	82 500 000,00	385 000 000,00	11%
4	Д.Зоригт	962 500 000,00	262 500 000,00	1 225 000 000,00	35%
5	Н.Энхболд	220 000 000,00	60 000 000,00	280 000 000,00	8%
6	Г.Батбаяр	137 500 000,00	37 500 000,00	175 000 000,00	5%
7	Г.Лхамсүрэн	110 000 000,00	30 000 000,00	140 000 000,00	4%
8	Ж.Өөдөс	275 000 000,00	75 000 000,00	350 000 000,00	10%
9	Л.Цэцэг-Эрдэнэ	55 000 000,00	15 000 000,00	70 000 000,00	2%
	Дүн	2 750 000 000,00	750 000 000,00	3 500 000 000,00	100,00%

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2015 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Миг даатгал” ХХК /Ж.Бат-Орших/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000561